



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№177 /387/

2022.10.04

Цаг үе, үйл явдал

20 ГАРУЙ БАЙГУУЛЛАГЫН ДАЙЧИД ӨРСӨЛДӨНӨ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас 10 дугаар сарын 7-ны өдөр төрийн цэргийн байгууллагуудын хугацаат цэргийн алба хаагчдын дунд “Цэргийн мэргэжлийн аварга түрүүч, байлдагч шалгаруулах тэмцээн”-ийг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Засвар хангалтын төвийн байрлалд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Тэмцээнд урьдчилсан байдлаар Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргийн 20 гаруй байгууллагын 50 орчим байлдагч, түрүүч оролцох мэдүүлгээ өгсөн бөгөөд техникийн зөвлөгөөн нь энэ пүрэв гаригт Хуурай замын цэргийн командлалд зохион байгуулагдана. Энэхүү тэмцээнд оролцогч түрүүч, байлдагч нар цэргийн хэргийн онолын мэдлэг, биеийн тамирын бэлтгэлжилтийн түвшин, нормативын бэлтгэл, буудлагаар өрсөлдөх юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 5	☁ -10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 29	☁ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,500	3,520
EUR	3,445	3,480
CNY	480	484
RUB	53	53.40
JPY	23.90	24.40
KRW	2.43	2.46

ЗУРХАЙ



2022.10.04 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 9

**НАМРЫН ДУНД САРЫН
ШАРАГЧИН ТАХИА САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ
ЦАГААН БАР ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин өчүүхэн ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.55-18.27
БАРИЛДЛАГА:
Түлэх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Төрөн түгэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 623,689,162

Эдгэрсэн

Нийт: 603,857,943

Нас барсан

Нийт: 6,551,724

“УЛААНХУАРАНГИЙН ТЭМДЭГЛЭЛҮҮД...” НОМ ХЭВЛЭГДЭН ГАРЛАА



Алдаргавьяаныхосодонт Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын түүхт 90 жилийн ойд зориулан бүтээсэн бэлтгэлд байгаа хошууч Самбуугийн Болдын “Улаанхуарангийн тэмдэглэлүүд...” ном хэвлэгдэн уншигчдын гарт хүрлээ. Дайны талбарт

дарийн утаа үнэртсэн цорын ганц мэргэжлийн урлагийн байгууллага төдийгүй 90 жилийн буурал түүхийг бүтээж яваа цэргийн чуулгын өрнүүн түүх, уран бүтээлчдийнхээ бахдам намтрыг хүүрнэх энэхүү номынхоо дээжийг зохиогч ЦДБЭЧ-ын дарга, Соёлын төв

өргөөний ерөнхий менежер хурандаа Г.Золзаяад гардуулан өглөө.

ЦДБЭЧ-ын ахмад уран бүтээлч, найруулагч С.Болдын энэ номд цэргийн ансамбль хэмээх их айлын тулгын чулуу, бахдам гавьяаг өргөлцсөн олон арван уран бүтээлчдийн

дурсамж, дурдатгал, бүтээл туурвилын өрнүүн түүх баримт, чуулгын сүүлийн жилүүдэд хийж хэрэгжүүлсэн урлаг соёлын арга хэмжээнүүд, уран бүтээлчдийн амжилтуудын тухай дэлгэрэнгүй орсон байна. Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги “9 дүгээр сарын сахилгын дунгийн хурал”-аа тайлагнахын зэрэгцээ Олон улсын Ахмадын баярыг тохиолдуулан ахмад дайчдаа хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Ангийн удирдлага алба хаагчдынхаа ажиллах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд хийж хэрэгжүүлсэн засвар, тохижилтын ажил, эх орны бүтээн

байгуулалтад оруулж буй хувь нэмэр, ололт амжилтаа хүрэлцэн ирсэн ахмад дайчдадаа танилцуулав.

Мөн хүндэтгэлийн зоог барин, үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн урлагийн хэсэгчилсэн тоглолтыг үзүүлж, дурсгалын зураг татуулсан юм.

ДЭСЛЭГЧ Т.БЯМБАСҮРЭН



Цахим шууданд

ЦЭРГИЙН ГЭРЭЭТ БОЛОН ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБЫГ СУРТАЛЧЛАХЫГ ҮҮРЭГ БОЛГОВ



Монгол Улсын холбогдуулан Зэвсэгт болгоод байна. хэмжээнд 2021 оны хүчний нэгтгэл, Ялангуяа, Зэвсэгт хоёрдугаар ээлжийн ангиудад алба хааж хүчний нэгтгэл, ангиудыг хугацаат цэргийг халах, байгаа дайчдыг олон хүчний нэгтгэл, ангиудыг 2022 оны хоёрдугаар нийтэд сурталчлах хэвлэл мэдээллийн ээлжийн хугацаат үүргийг Зэвсэгт хүчний байгууллагатай хамтран цэргийг татах үйл Жанжин штабаас контент, нэвтрүүлэг ажиллагаа эхлээд Төрлийн цэргийн иргэн-цэргийн командлал болон батлан харилцааг бэхжүүлэхэд байна. Хугацаат хамгаалах салбарын идэвх санаачилгатай цэрэг татах, халах хэвлэл мэдээллийн ажиллах талаар ЗХЖШ-үйл ажиллагаатай байгууллагуудад үүрэг аас үүрэг чиглэл өглөө.

ТАЛАРХЛЫН ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Олон Улсын Ахмадын баярын өдрийг тохиолдуулан Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын 90 жилийн түүхт ойн хүрээнд “Хан эгшиг” НҮТББ-тай хамтарсан талархлын өдөрлөгийг зохион байгууллаа. Ой угтсан өрнүүн ажлын нэг болсон тус өдөрлөгт ЦДБЭЧ-ын үеийн хөгжмийн удирдаач нарын бүтээл эгшиглэж, хөгжмийн албаны ахмадууд, Ахмадын хорооны тэргүүлэгч гишүүд, “Хан эгшиг” НҮТББ тэргүүлэгчид, дэмжигч гишүүд оролцлоо. Мөн 2022.09.30-10.01-ний өдрүүдэд чуулгын дарга асан, ахмад бүжигчин Х.Ёндонгийн 100 насны ойд зориулсан “Монгол бүжгийн гайхамшиг III” уралдааныг түүний үр хүүхдүүдтэй хамтран Хэнтий аймгийн Баян-Овоо суманд амжилттай зохион байгуулж, ЦДБЭЧ-ын бүжгийн тоглолтыг нутгийн ард иргэдэд толилуулжээ.

АХМАД АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАА ХҮЛЭЭН АВЛАА



Олон улсын шинжилгээ судалгаа, музейн хашаанд 25 Ахмадын өдрийг үзүүлэг сан хөмрөг, ш голт бор мод тарьж, тохиолдуулан эх түүх, байнгын болон түр музейн гадна талбайн өв соёлоо хадгалан цахим үзэсгэлэн тохижилт үйлчилгээнд хамгаалах, Монгол зохион байгуулах дэмжлэг үзүүллээ. цэргийн түүх, Зэвсэгт талаар хийсэн Мөн цаашид хүчний дайчин ажил, мөн гадаад музейн удирдлага, уламжлалыг залуу харилцаагаа хөгжүүлж, ахмадын зөвлөлтэй үедээ сурталчлан олон улсын үйл хамтран ахмадуудын таниулах үйлст залуу ажиллагаанд оролцсон эрүүл мэндийг халуун насаа зориулж талаараа ахмадууддаа анхаарах, музейн өдгөө гавьяаныхаа тайлагнасан юм. үзүүлэг сурталчилгаанд амралтыг эдэлж буй Хүрэлцэн чиглэсэн ажил арга ахмадуудаа Монгол ирсэн эрхэм зочид, хэмжээнд хамтран цэргийн музейн ахмадууд өөрсдийн ажиллах, тэдний удирдлага хүлээн авч санаачилгаар Монгол ажлын туршлагыг хүндэтгэл үзүүллээ. Улсын Ерөнхийлөгчийн боловсролын болон хүндэтгэл үзүүллээ. сурталчилгаа, хөдөлгөөнд нэгдэж, санал солилцжээ.



ФОТО АГШИН



Энх цагийг авч ирсэн ахмад дайчин танд БАЯРЛАЛАА.